ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2026 оны 10 сарын 08 өдөр Дугаар 74 Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, "Худалдаа, хөгжлийн банк" ХК (цаашид "Банк" гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны холбогдох этгээд болох "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй "Зээлийн нэмэлт гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлтэй холбогдуулан "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **РАНДОЛФ КОППА**

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК 9023088616 6355534 ATA10359 TRADE AND DEVELOPMENT BANK JSC